



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Г

Арилжаанд оролцох эрхийг
сэргээх тухай

Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.9.3, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтууд болон “Ди си эф ҮЦК” ХХК-ийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн №024/003 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/106 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг нь хязгаарлсан “Ди си эф ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг “Ди си эф ҮЦК” ХХК /Б.Батбаяр/-д анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЦОГТБАЯР

1523030064